



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 18 өдөр


Дугаар A/197

Мандалговь

Тусгай зөвшөөрөл сунгах тухай

Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.14, 7 дугаар зүйлийн 7.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3, 16.3.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг “Аяны анд” хүнсний дэлгүүрт тамхи худалдан борлуулах тусгай зөвшөөрлийн эрхийг 2021 оны 11 дүгээр сарын 18-ны өдрөөс 2023 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийг хүртэл хугацаагаар сунгаж олгосугай.
2. Утаат тамхи худалдан борлуулах үйл ажиллагаа эрхлэхдээ хууль, журамд заасан тавигдах шаардлагыг биелүүлж, үйл ажиллагаа явуулж буй объектынхоо эргэн тойрны 50 метр газрын цэвэрлэгээ болон хотын тохижилт, соёлжилтод онцгой анхааран, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ажиллахыг иргэн (С.Оргилбаатар)-д үүрэг болгосугай.
3. Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг худалдаа үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн (Э.Цэрэннадмид), Цагдаагийн хэсгийн байцаагч (М.Мөнхбат, Б.Хүслэн, Б.Батбаяр) нарт үүрэг болгосугай.



ЗАСАГ ДАРГА

С.БАТ-ОРГИЛ